

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:
АРА-2021/01/-СТА-ТЕЗ



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2021 ОН

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр
Утас: 7033-3141 Цахим хаяг: ulambayard@audit.gov.mn
Аудитын менежер Т.Байгалмаа
Утас: 7033-2860 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Алтантуяа
Утас: 9933-8611 Цахим хаяг: altantuyan@audit.gov.mn
Аудитор В.Цогжаргал
Утас: 9915-8257 Цахим хаяг: tsogjargalv@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Агуулга

Агуулга	1
1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4 Материаллаг байдал	12
3.5.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	13
3.5.3 БАРАА МАТЕРИАЛ.....	19
3.5.5 Үндсэн хөрөнгө	21
3.5.6 ӨР ТӨЛБӨР	23
3.5.7 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	26
3.7 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	27
3.8 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА.....	27
3.9 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН.....	29
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	32
4. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	33
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	35
6. Аймгийн ТЕЗ-аас ирүүлсэн асуудлын бүртгэлийн хариу	36
7. Адитын тайлан баталгаажуулсан тушаал	38
8. Хүргүүлсэн албан шаардлага	40

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БТСГ	Биеийн тамир спортын газар
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЦСҮТ	Цөм сүргийн үржлийн төв
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1. Аудитын гэрчилгээ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
Д.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

2021.04.23 № 151
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Архангай аймгийн засаг дарга бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 онд яамдын сайдуудтай байгуулсан гэрээнд 563 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

003020359

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,488,180.3	26,602,284.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,917,514.9	11,460,798.9
33	АВЛАГА	7,295,438.6	7,681,234.1
35	БАРАА МАТЕРИАЛ	5,655,058.6	6,997,875.9
36	НӨӨЦИЙН БАРАА	124,256.8	80,422.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	15,495,911.4	381,953.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	170,272,874.1	194,475,155.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	170,272,874.1	194,475,155.7
39200	Биет хөрөнгө	162,179,685.5	186,276,159.9
39300	Биет бус хөрөнгө	7,932,672.2	8,007,038.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	160,516.4	191,957.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	208,761,054.4	221,077,440.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,400,300.2	12,407,862.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,171,293.0	1,236,906.1
41200	Богино хугацаат зээлийн өглөг	0.0	5,100.0
41300	Өглөг	5,136,817.4	1,191,177.4
41400	Урьдчилж орсон орлого	34,475.6	40,628.7
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,229,007.3	11,170,956.5
42200	Урт хугацаат зээл	2,229,007.3	11,170,956.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	201,360,754.1	208,669,577.8
51	Засгийн газрын хувь оролцоо	201,360,754.1	208,669,577.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	57,402,649.2	57,480,817.2
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,442,855.9	4,704,604.7
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,395,610.0	3,414,850.9
51200	Хуримтлагдсан үр дүн	87,094,002.1	96,927,055.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,025,636.9	46,142,249.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	208,761,054.4	221,077,440.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	198,591,974.4	146,586,588.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,519,243.2	12,526,190.1
110	Орлогын албан татвар	6,362,691.8	7,867,649.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,006,107.6	8,426,313.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-643,415.9	-559,294.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	630.0
113	Хөрөнгийн албан татвар	705,448.1	739,535.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,451,103.4	3,919,005.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,944,502.4	108,001,979.6
120	Нийтлэг татварын бус орлого	35,461,141.1	40,021,801.8
121	Хөрөнгийн орлого	49,914.0	63,724.3
122	Тусламжийн орлого	373.0	2,800.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	56,433,074.3	67,913,653.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	98,128,228.8	26,058,418.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	150,011,290.5	103,535,110.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	150,011,290.5	103,535,110.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,286,081.0	99,399,465.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,530,870.0	46,855,087.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,978,024.7	6,122,700.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,566,316.0	5,731,485.9
2104	Хангамж, бараа материалын зардал	2,758,346.1	2,575,656.3
2105	Нормативт зардал	3,201,663.7	4,556,533.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	550,656.0	732,414.9
2107	Томилолт, зочны зардал	323,313.1	193,576.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,874,182.4	3,409,463.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,502,709.1	29,222,546.0
212	ТАТААС	126,184.2	87,885.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,599,025.3	4,047,760.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	48,580,683.9	43,051,478.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	31,027,140.3	39,818,309.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	17,553,543.6	3,233,168.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	172,112,313.1	113,053,539.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,519,243.2	12,526,190.1
110	Орлогын албан татвар	6,362,691.8	7,867,649.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,006,107.6	8,426,313.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-643,415.9	-559,294.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	630.0
113	Хөрөнгийн албан татвар	705,448.1	739,535.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,451,103.4	3,919,005.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	499,511.0	478,142.6
1181	Газрын төлбөр	442,507.0	613,175.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	509,085.4	2,827,687.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,500,732.4	74,468,930.8
120	Нийтлэг татварын бус орлого	9,017,744.0	6,491,553.0
121	Хөрөнгийн орлого	49,914.0	63,724.3
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	56,433,074.3	67,913,653.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	98,092,337.5	26,058,418.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	139,921,873.7	78,742,344.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	139,921,873.7	78,742,344.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,278,695.3	75,198,184.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,979,936.3	47,198,029.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,073,589.5	6,285,361.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,352,796.3	5,797,343.3
2104	Хангамж, бараа материалын зардал	2,458,777.2	2,168,393.5
2105	Нормативт зардал	3,349,364.2	4,191,835.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	751,508.7	777,306.5
2107	Томилолт, зочны зардал	325,961.7	194,091.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,251,304.6	3,476,822.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,735,456.8	5,109,001.0
212	ТАТААС	126,184.2	87,841.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,516,994.2	3,456,318.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	32,190,439.3	34,311,194.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	28,214,588.7	31,110,650.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,214,588.7	31,110,650.5
2200	Дотоод эх үүсвэрээр	28,214,588.7	31,110,650.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-28,214,588.7	-31,110,650.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,597,661.8	-1,657,260.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,593,950.0	1,653,740.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,711.8	3,520.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,378,188.8	1,543,284.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,539,326.1	9,917,514.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,917,514.9	11,460,798.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	180,655,206.3	0.0	180,655,206.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	171,074.6	0.0	171,074.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	180,826,280.9	0.0	180,826,280.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-85,891.9	0.0	-85,891.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,960,310.3	0.0	2,960,310.3
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	106,511.2	0.0	106,511.2
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	17,553,543.6	0.0	17,553,543.6
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	201,360,754.1	0.0	201,360,754.1
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	201,360,754.1	0.0	201,360,754.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,598,775.8	0.0	6,598,775.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	207,959,529.9	0.0	207,959,529.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-3,883,387.4	0.0	-3,883,387.4
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,359,157.7	0.0	1,359,157.7
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	3,233,168.7	0.0	3,233,168.7
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	208,669,577.8	0.0	208,669,577.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт,	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,942,039.3	79,350,238.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	75,475,849.2	72,635,253.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,672,416.0	71,120,102.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,607,857.3	46,329,286.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,286,564.3	6,099,849.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,854,601.8	5,536,219.1
2104	Хангамж, бараа материалын зардал	2,248,054.7	2,163,587.8
2105	Нормативт зардал	5,478,639.9	4,107,406.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	874,035.3	850,612.1
2107	Томилолт, зочны зардал	191,315.6	161,081.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,522,405.7	2,389,180.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,608,941.4	3,482,879.8
212	ТАТААС	107,961.8	87,841.8
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	20,000.0	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	87,961.8	87,841.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,695,471.4	1,427,309.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	140,000.0	140,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,555,471.4	1,287,309.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,391,674.7	5,061,244.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,074,515.4	1,653,740.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	84,942,039.3	78,428,693.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	50,523,597.7	48,580,460.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,254,842.8	27,619,782.9
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	642,865.3	572,695.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,520,733.5	1,655,754.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,299,847.2
5	Мөнгө, түүнтэй адилтгаа хөрөнгийн эхний үлдэгдэл		1,377,090.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт,	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,298,706.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,141,831.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,953,200.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		340,312.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		41,030.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		8,936.5
2104	Хангамж, бараа материалын зардал		225,217.6
2105	Нормативт зардал		64,534.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		137,607.8
2107	Томилолт, зочны зардал		33,009.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		620,874.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,481,677.4
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		87,841.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		188,630.4
2132	Бусад урсгал шилжүүлэг		11,186.5
2133	Олгосон, санхүүжилт шилжүүлэг		177,443.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		156,875.0
221	Дотоод эх үүсвэрээр		156,875.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,295,577.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,295,577.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,128.7

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Д.Золжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 05-аас 2021 оны 04 дүгээр сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Н.Алтантуяа, аудитор В.Цогжаргал нар гүйцэтгэв.

Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/425 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Аймгийн ТЕЗ-ийн зорилго, үйл ажиллагааг Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Орон нутгийн уламжлалт технологиор хийж бүтээж байсан баялаг туршлага, үржил шимт үзэсгэлэнт газар нутаг, мал сүрэг, оюуны өндөр чадамжтай иргэдээ түшиглэсэн хөнгөн үйлдвэрийн цогц бодлогыг хэрэгжүүлж тогтмол орлого, байнгын ажлын байраар иргэдээ хангаж тогтвортой эдийн засаг, нийгэм, ногоон хөгжлийг цогцлоон төрөлх нутгаа хөгжүүлэх нь бидний эн тэргүүний зорилт байх болно” гэж тодорхойлсон байна.

Аймгийн ТЕЗ-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Тогтвортой эдийн засгийн хөгжлийн хүрээнд бүс нутгийн хэрэглээг хангахад чиглэгдсэн үйлдвэрүүдийг дэмжиж, импортыг орлох, гадаад зах зээлд чиглэсэн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, иргэдийнхээ тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Тогтвортой нийгмийн хөгжлийн хүрээнд гэр бүлийг дэмжин тэтгэх, иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд бүх талаар анхаарч ажилгүйдэл, ядуурлыг бууруулан дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж, иргэдийнхээ амьжиргааг сайжруулна.
- Тогтвортой ногоон хөгжлийн хүрээнд ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн байгаль орчны унаган төрх, эко системийн тэнцвэрт байдлыг хадгалж, баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргэх, аялал жуулчлалын салбарыг хөгжлийн нэг тулгуур болгон хөгжүүлнэ.

- Тогтвортой засаглалын бүх шатанд мэргэшсэн, чадвартай төрийн албан хаагчид иргэдэд хөнгөн шуурхай чирэгдэлгүй, ил тод, нээлттэй үйлчлэн, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, тогтвортой засаглалыг бэхжүүлнэ.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүү, НББ-д мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. Энэ нь НББ-ийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, улмаар санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримтлах зарчим алдагдах үр дагавартай байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар УСНББОУС болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулахад тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн СТСХ-т хүргүүлсэний дагуу Сумдын орон нутгийн удирдлагын байгууллагуудын 2021 оны төсөвт Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг хийлгэх зардлыг төлөвлөн батлуулсан бөгөөд 2021 онд бүрэн хэрэгжихээр байна.

Аймгийн ТЕЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг “Үр нөлөөтэй” гэж үзлээ. Гэсэн хэдий ч 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 22 байгууллагатай холбоотой 92.0 сая төгрөгийг төсөвт зохицуулалт хийлгүйгээр зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрсэн нь сумдын төрийн сангийн төлбөр тооцоонд тавих хяналт сул байгааг харуулж байна.

Аймгийн засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагуудын шилэн дансанд, 57 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч, аймгийн ТЕЗ-д танилцуулан, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр зөвлөмж бэлтгэж, төсөв захирагч нарт хүргүүлэн, биелэлтийг тооцон ажилласан байна.

Төсвийн шууд захирагчийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 69 байгууллагатай холбоотой дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчил илэрсэнд аудитаас зөвлөмж хүргүүлэн ажилласан.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, орон нутгийн тусгай сан, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангууд нэгтгэгддэг тул материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд аймгийн ТЕЗ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 148,237.8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 1,482.4 сая төгрөгөөр тогтоолоо.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 1,433.5 сая төгрөгөөр тогтоосон нь аймгийн ТЕЗ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал устгах бичилт хийгдэж 143,353.4 сая төгрөгөөр тайлагнагдсантай холбоотой болно.

3.5 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.5.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл **9,917.5** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **11,460.8** сая төгрөг болж, **1,543.3** сая төгрөгөөр өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 95.7 хувь буюу 10,967.0 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 4.3 хувь буюу 492.8 сая төгрөг нь арилжааны банкинд байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Кассад байгаа бэлэн мөнгө	12.9	1.0	(11.9)	0.01
Банкинд байгаа бэлэн мөнгө:	9,904.6	11,459.8	1,555.2	99.99
Төрийн сангийн харилцах	9,388.0	10,967.0	1,579.0	95.69
Арилжааны банкны харилцах	516.6	492.8	(23.8)	4.30
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	9,917.5	11,460.8	1,543.3	100.00
Үүнээс байгууллагын төрлөөр:				
Төсвийн байгууллага	2,304.6	1,335.0	(969.6)	11.65
Төрийн сан	3,110.4	6,717.7	3,607.3	58.61
Төсөл сан	3,982.2	2,914.3	(1,067.9)	25.43
ОНӨҮГазар	520.3	493.8	(26.5)	4.31
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	9,917.5	11,460.8	1,543.3	100.00

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 11.6 хувь буюу 1,335.0 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 58.6 хувь 6,717.7 сая төгрөгийг төрийн сангийн, 25.5 хувь буюу 2,914.3 сая төгрөгийг төсөл сангийн, 4.3 хувь буюу 493.8 сая төгрөгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үлдэгдэл тус тус эзэлж байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө байршиж буй хэлбэр /сая төгрөг/

Үүнээс байгууллагын төрлөөр:	Мөнгөн хөрөнгө байршиж буй хэлбэр			Нийт мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл
	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө :		
		Төрийн сан	Арилжааны банк	
Төсвийн байгууллага		1,335.0		1,335.0
Төрийн сан		6,717.7		6,717.7
Төсөл сан		2,914.3		2,914.3
ОНӨҮГазар	1.0		492.8	493.8
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	1.0	10,967.0	492.8	11,460.8

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 95.7 хувь төрийн сангийн харилцах дансанд, 4.3 хувь арилжааны банкинд байршсан байна.

Төрийн сангийн харилцах дансанд байршиж буй мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 9,388.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 10,967.0 сая төгрөг болж, 1,579.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	2,200.1	1,335.0	(865.1)
1.1	Сумдын ОНХС /19 сум/	717.2	671.9	(45.3)
1.2	Аймгийн ОНХС	537.1	37.8	(499.3)
1.3	Сум хөгжүүлэх сан/19 сум/	945.8	625.3	(320.5)
2	Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	3,110.4	6,717.7	3,607.3
2.1	Төрийн сангийн үлдэгдэл -ОНЕО /19 сум/	1,626.9	4,400.7	2,773.8
2.2	Төрийн сангийн үлдэгдэл -ОНЕО /аймаг/	1,483.5	2,317.0	833.5
3	Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	4,077.5	2,914.3	(1,163.2)
3.1	Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн данс	3,732.4	2,569.4	(1,163.0)
3.2	Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн данс	249.8	162.3	(87.5)
3.3	Техник хяналтын зардлын данс	-	140.5	140.5
3.4	Аймгийн мал хамгаалах сан	95.3	42.1	
Төрийн сангийн нийт мөнгөн хөрөнгийн дүн /1+2+3/		9,388.0	10,967.0	1,579.0

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн байгууллага ангилалд аймаг, сумдын ОНХС-ийн 709.7 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн 625.3 сая төгрөг тус тус тайлагнагдсан байна. Харин төрийн сан ангилалд аймаг, 19 сумын орон нутгийн ерөнхий орлогын дансны 6,717.7 сая төгрөгийн үлдэгдэл, төсөл сан ангилалд аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансны 2,569.4 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн 162.3 сая төгрөг, техник хяналтын зардлын 140.5 сая төгрөг, мал хамгаалах сангийн 42.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тус тус байна.

Аймгийн төрийн сангийн ерөнхий орлогын дансанд 2,317.0 сая төгрөгийн үлдэгдэл байгаа ба үүнд халамжийн сангаас 12.1 сая төгрөг, орон нутгийн төсөвт байгууллагуудын хэмнэлтээр төвлөрүүлсэн 560.0 сая төгрөг, бусад нь орон нутгийн давсан орлогын үлдэгдэл тус тус байна.

Сумдын орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл өмнөх оноос 2,773.8 сая төгрөгөөр өссөн нь Жаргалант, Ихтамир, Булган, Цэнхэр сумдад байгалийн ургамал ашигласны төлбөр буюу хуш модны самрын орлого өндөр дүнгээр давж биелэсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 3,732.4 сая төгрөг, тайлант онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 2020 оны зарцуулагдаагүй үлдэгдэл 2,036.8 сая төгрөгийг байршуулснаас 3,199.8 сая төгрөгийн зарцуулалт гарч, оны эцэст 2,569.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Техник хяналтын зардал дансанд 615.7 сая төгрөгийн улсын төсвийн эрх шилжсэн болон Зам Тээврийн Яамны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний техник хяналтын зардлыг төвлөрүүлэн, 475.2 сая төгрөгийг зарцуулж, 140.5 сая үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансны эцсийн үлдэгдэл 162.3 сая төгрөгийг тодруулбал:

- Зах зээл ба бэлчээрийн удирдлагыг хэрэгжүүлэх төслийн үлдэгдэл санхүүжилт 85.6 сая төгрөг,
- ЗГХЭГ-аас сум багийн хөгжлийг дэмжих, чадавхижуулах хөтөлбөрийн үлдэгдэл санхүүжилт 4.9 сая төгрөг,
- БОАЖЯ-ны орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос аймгийн төвийн хогийн цэгийг дарж булшлах ажлын үлдэгдэл санхүүжилт 0.8 сая төгрөг,
- Аймгийн засаг дарга дансны 8.9 сая төгрөг,
- Аймгийн засаг даргын А/913 тоот захирамжаар засаг даргын нөөц сангаас олгох Хайрхан суманд гарсан малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх зардал 10.9 сая төгрөг,
- БТСГ 13.1 сая төгрөг, Төвшрүүлэх сумын 15.2 сая төгрөг, Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 1.8 сая төгрөг, Эрдэнэбулган сумын ирээдүй цэцэрлэг 1.5 сая төгрөг, Хайрхан сумын ЕБС 1.0 сая төгрөг, ГХБХБГ-ын 3.5 сая төгрөг зэрэг нэмэлт санхүүжилтийн буцаан төвлөрүүлэлт
- Өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдэл 15.1 сая төгрөг тус тус байна.

Мал хамгаалах сангийн эхний үлдэгдэл 95.3 сая төгрөг, тайлант онд 20.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, 74.1 сая төгрөгийн зарцуулалт гарч, оны эцэст 42.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Арилжааны банкны харилцах дансанд байршиж буй мөнгөн хөрөнгө

ОНӨҮГ-уудын мөнгөн хөрөнгө нь арилжааны банкинд байршиж байгаа бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 82.3 хувь нь хугацаатай хадгаламж, 17.7 хувь нь харилцах дансны үлдэгдэл байна.

Хүснэгт № 4 Арилжааны банкны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллагын нэр	Үлдэгдэл		Нийт үлдэгдэл	Дансны тоо
	Харилцах данс	Хугацаатай хадгаламж		
Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ	5.6		5.6	1
Ундарга ОНӨХХК	78.7	405.6	484.3	8
Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ	2.9		2.9	1
НИЙТ ДҮН	87.2	405.6	492.8	10

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Төвшрүүлэх сумын ЕБС -26.7 сая төгрөг, Хайрхан сумын ЕБС- 51.3 сая төгрөг, Хангай сумын ЕБС -24.8 сая төгрөг, Хашаат сумын ЕБС -9.3 сая төгрөг, Цахир сумын ЕБС -18.4 сая төгрөг, Цэнхэр сумын ЕБС -58.2 сая төгрөг, Цэцэрлэг сумын ЕБС -34.4 сая төгрөг, Чулуут сумын ЕБС – 48.9 сая төгрөг, Эрдэнэмандал сумын ЕБС-162.9 сая төгрөг, Өлзийт сумын ЕБС -19.1 сая төгрөг, Булган сумын ЕБС-18.4 сая төгрөг, Эрдэнэбулган сумын 1-р сургууль- 30.7 сая төгрөг, 2-р сургууль-17.7 сая төгрөг, 3-р сургууль- 8.9 сая төгрөг, 5-р сургууль- 19.4 сая төгрөг, Хоршоолол бага сургууль 1.1 сая төгрөг, Архангайд үйлдвэрлэв ОНӨҮГ 21.5 сая төгрөг нийт **571.5** сая төгрөгийн цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн зөрчил илэрсэнд аудитаас НББ-ийн болон Татварын ерөнхий хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.
- Жаргалант сумын ЕБС нь 15.5 сая төгрөгийн төсвийн үлдэгдлийг НДХ-т илүү тооцоо үүсгэн шилжүүлсэнд төлбөрийн акт тогтоосон.

- БШУС-ын 2019 оны “ЕБС-ийн суралцагчдад сурах бичиг түрээсээр төлбөртэй ашиглуулах” журам батлах тухай А/302 дугаар тушаалын 3.2-д “төлбөрийг төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн суралцагч сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд тушаана” гэж заасныг зөрчин Жаргалант сумын ЕБС 4.5 сая төгрөгийн, Өндөр-Улаан сумын ЕБС- 3.7 сая төгрөгийн сурах бичгийн түрээсийн төлбөрийг бэлнээр авч, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэлгүйгээр өөр дансанд тушаасан зөрчил илэрсэнд аудитаас алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, журмыг хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.
- Аймгийн ИТХурал ажилчдыг идэвх зүтгэл гаргаж, үр дүнтэй ажилласан эсэхийг үнэлж дүгнэсэн анхан шатны нотлох баримтгүйгээр ИТХТ-ийн нарийн бичгийн даргын 2020.12.13-ны өдрийн А/81 тоот тушаалаар ажилчдад нийт 5.0 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгосонд аудитаас зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэн ажиллалаа.
- Өлзийт сумын хүүхдийн цэцэрлэг нь 1 болон 2-р гарын үсгээр баталгаажаагүй 37.0 сая төгрөгийн төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийсэнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.
- Хотонт сумын ЭМТ нь бараа үйлчилгээний бусад зардлаас анхан шатны баримтгүйгээр 1.2 сая төгрөгийг сургалтанд зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.
- Хотонт сумын ЗДТГ засаг даргын нөөц сангаас анхан шатны баримтгүйгээр 1.7 сая төгрөгийг зарцуулж, 0.2 сая төгрөгийг засаг даргын захирамжийн мөнгөн дүнгээс илүү тооцож шилжүүлсэнд төлбөрийн акт тогтоосон.
- Өндөр-Улаан сумын ЗДТГ нь 0.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэнд албан шаардлага хүргүүллээ.
- Архангайд үйлдвэрлэв ОНӨҮГ 4.1 сая төгрөгийн түлш, шатахуун зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, хангалтгүй зэрэг зөрчил илэрсэнд аудитаас зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн байна.

3.5.2 АВЛАГА

Авлагын дансны оны эхний үлдэгдэл **7,295.4** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **7,681.2** сая төгрөг болж, **385.8** сая төгрөгөөр өссөн байна. Нийт авлагын 98.6 хувь нь хувь хүнээс авах авлага, 1.4 хувь нь байгууллагаас авах авлага болон бусад авлага тус тус эзэлж байна.

Хүснэгт №5. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой авлага	3.7	12.4	8.7	0.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	5.8	4.2	(1.6)	0.1
Байгууллагаас авах авлага	77.7	52.6	(25.1)	0.7
Дансны авлага/ ТӨҮГ/	37.1	35.5	(1.6)	0.5
Татвар НДШ -ийн авлага /ТӨҮГ/	0.2	1.4	1.2	0.0
Хувь хүнээс авах авлага	7,170.9	7,575.1	404.2	98.6
Нийт дүн	7,295.4	7,681.2	385.8	1.4
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:				
Төсвийн байгууллага	7,178.2	7,548.3	370.1	98.3
Төрийн сан	46.4	46.4	-	0.6
Төсөл сан	33.9	44.8	10.9	0.6
ОНӨҮГазар	36.9	41.7	4.8	0.5
Нийт дүн	7,295.4	7,681.2	385.8	100.0

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 98.3 хувь буюу 7,548.3 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 0.6 хувь буюу 46.4 сая төгрөг нь төрийн сангийн, 0.6 хувь буюу 44.8 сая төгрөг нь төсөл сангийн, 0.5 хувь буюу 41.7 сая төгрөг нь ОНӨҮГ-ын авлага байна.

Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагын авлага ангилалд тайлагнагдсан нийт 7,548.3 сая төгрөгийн авлагын 97.9 хувь буюу 7,391.9 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн, 0.7 хувь нь 53.8 сая төгрөг нь сумдын ОНХС-ийн, 0.7 хувь буюу 50.0 сая төгрөг нь аймгийн засаг даргын хөтөлбөр арга хэмжээний зардлаас олгосон зээл, 0.7 хувь буюу 52.6 сая төгрөг нь аймаг, сумдын зарим төсөвт байгууллагуудын авлага байна.

Хүснэгт № 6 СХС-ийн авлагын үлдэгдэл /сая төгрөг/

№	Сумдын нэр	Авлагын эхний үлдэгдэл	Авлагын эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Ихтамир	438.4	476.9	38.5
2	Чулуут	267.0	325.7	58.7
3	Хангай	285.7	261.6	(24.1)
4	Тариат	406.6	470.0	63.4
5	Өндөр-Улаан	400.4	410.4	10.0
6	Эрдэнэмандал	284.1	316.4	32.3
7	Жаргалант	323.3	390.6	67.3
8	Цэцэрлэг	320.4	340.2	19.8
9	Хайрхан	373.5	346.9	(26.6)
10	Батцэнгэл	305.8	369.8	64.1
11	Өлзийт	302.4	322.5	20.1
12	Өгийнуур	288.4	282.8	(5.6)
13	Хашаат	315.6	306.6	(9.0)
14	Хотонт	314.5	379.2	64.7
15	Цэнхэр	314.3	332.1	17.8
16	Төвшрүүлэх	369.6	348.5	(21.1)
17	Булган	274.3	266.9	(7.4)
18	Эрдэнэбулган	1,162.7	1,182.5	19.8
19	Цахир	260.4	262.3	1.9
	ДҮН	7,007.4	7,391.9	384.6

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 7,391.9 сая төгрөг болж өмнөх оноос 384.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Зээлийн авлагыг хугацаагаар нь ангилж авч үзвэл:

Нийт авлагын 52.6 хувь буюу 3,889.3 сая төгрөг нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 15.9 хувь буюу 1,176.4 сая төгрөг нь зээл төлөх хуваариас 90 хүртэл хоног хэтэрсэн зээл, 31.5 хувь буюу 2,326.2 сая төгрөг нь 90-ээс дээш хоногоор хэтэрсэн зээл байна. Өөрөөр хэлбэл нийт авлагын 47.4 хувь нь хугацаа хэтэрсэн зээлийн авлага байгаа бөгөөд тус зээлүүдийг төлүүлэх талаар сумын засаг дарга нарын зүгээс хугацаатай мэдэгдэл хүргүүлэн, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэн ажиллаж байгаа хэдий ч зээлийн эргэн төлөлт хамгийн бага төвлөрүүлсэн сумдуудад Өлзийт 5.8 сая төгрөг, Чулуут 10.8 сая төгрөг, Булган 14.8 сая төгрөг, Хашаат 18.3 сая төгрөг тус тус байна.

Мөн хамгийн өндөр хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй сумдад Эрдэнэбулган 1,013.8 сая төгрөг, Ихтамир 248.7 сая төгрөг, Хашаат 241.9 сая төгрөг, Өлзийт 204.5 сая төгрөг, Чулуут 201.5 сая төгрөг тус тус байна.

Сумын ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлүүдийг барагдуулах талаар дорвитой арга хэмжээ авч, эргэн төлөлтийг эрчимжүүлэн ажиллах зөвлөмжийг бүх сумдын удирдлагуудад хүргүүлээд байна.

Төсөвт байгууллага ангилалд тайлагнагдсан 20.0 сая төгрөгийн авлага нь аймгийн засаг даргын хөтөлбөр арга хэмжээний зардлаас 2017 онд Хайрхан сумын малчин О.Доржтой аймгийн шилмэл үүлдрийн хээлтүүлэгч бог малын үүлдэр угсааг сайжруулах төсөл хэрэгжүүлэхээр эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гэрээ байгуулан олгосон бөгөөд малчин О.Доржийн хүсэлтийн дагуу гэрээнд 2018 оны 10-р сард өөрчлөлт оруулан 2018, 2019, 2020 онууд шилмэл омгийн хуц нийлүүлэн зээлийг төлж барагдуулах гэрээ хийсэн байна. 2020 онд тус гэрээний хугацаа дуусч авлага төлөгдөх байсан боловч зээл төлөгдөөгүй, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна. Аудитаас авлагыг барагдуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах албан шаардлагыг хүргүүлээ.

Төрийн сангийн авлага

Төрийн сангийн авлага 46.3 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 39.8 сая төгрөг нь 2001 онд үүссэн 19 жилийн насжилттай өвс тэжээлийн авлага, 6.5 сая төгрөг нь Атрын 3-р аяны хүрээнд иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн авлага бөгөөд ямар байгууллага, хувь хүнээс авах нь тодорхойгүй эзэн холбогдоггүй байна. Эдгээр авлагыг барагдуулах талаар өмнөх жилүүдийн аудитаар зөвлөмж хүргүүлэн, УАГ-т санал уламжилж байсан боловч шийдэгдээгүй, 2020 онд уг авлага тайланд тусгагдсан хэвээр байна.

Төсөл сангийн авлага

Төсөл сан ангилалд тайлагнагдсан нийт 44.8 сая төгрөгийн авлагын 97.9 хувь буюу 33.9 сая төгрөг нь Эрдэнэбулган сумын малчин өрхийн орлого нэмэгдүүлэх сангийн зээлийн авлага, 2.1 хувь нь аймгийн мал хамгаалах сангийн 10.9 сая төгрөгийн авлага байна.

Эрдэнэбулган сумын малчин өрхийн орлого нэмэгдүүлэх сангийн авлага нь 2013-2015 онуудад 17 иргэнд олгосон, 8 жилийн насжилттай авлага бөгөөд тус зээлийг төлүүлэхээр хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн ажиллаж байгаа тайлбарыг ирүүлээд байна.

Аймгийн мал хамгаалах сангийн 10.9 сая төгрөгийн авлагын 3.9 сая төгрөг нь 2013-2016 онуудад, 7.1 сая төгрөг нь 2018 онд үүссэн хувь хүнээс авах өвс тэжээлийн авлага бөгөөд авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна. Аудитаас авлагыг барагдуулж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

ОНӨҮГ-ын авлага

ОНӨҮГ-ууд нь нийт 41.7 сая төгрөгийн авлагатайгаас 80.3 хувь буюу 33.5 сая төгрөг нь Ар-ус Ундарга ХХК ОНӨҮГ-ын, 15.6 хувь буюу 6.5 сая төгрөг нь Архангайд үйлдвэрлэв ОНӨҮГ-ын, 4.1 хувь буюу 1.7 сая төгрөг нь Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨҮГ-ын авлага байна.

Ар-ус Ундарга ХХК ОНӨҮГ-ын 33.5 сая төгрөгийн авлагыг тодруулбал: Байгууллагаас авах авлага 6.8 сая төгрөг, ажилчид албан хаагчдаас авах авлага 26.5 сая төгрөг, татвар шимтгэлийн илүү төлөлт 0.2 сая төгрөг тус тус байна.

Аудитын илрүүлэлт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Хот тохижилт үйлчилгээний газар 4.2 сая төгрөгийн тээвэр шатахууны зардлыг илүү шилжүүлэн авлага үүсгэсэн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.
- ОНӨГ нь шүүхийн шийдвэрийн дагуу орон нутгийн төсөвт төлүүлэхээр шийдвэрлэсэн 85.0 сая төгрөгийн авлагыг бүртгэл тайланд тусгаагүй зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн.
- ОНӨГ-т шүүхийн шийдвэрээр найдваргүй болох нь тогтоогдсон 6.1 сая төгрөгийн авлагыг өмнөх үеийн үр дүн рүү хааж бууруулах бичилт хийснийг аудитын явцад найдваргүй авлагын зардалд бүртгэх залруулгыг хийлгэлээ.
- Төвшрүүлэх сумын хүүхдийн цэцэрлэгт тэтгэвэр тогтоолгосон ажилтаны НДШ-ийг илүү тооцон шилжүүлж, 0.7 сая төгрөгийн авлага үүсгэсэнд төлбөрийн акт тогтоолоо.
- Өндөр-Улаан сумын ЗДТГ-т 0.4 сая төгрөгийн ажилчдаас авах авлагыг бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсанд залруулга хийлгэн бүртгүүлээ.
- Хайрхан сумын ЭМТ нь жирэмсний амралттай хүний НДШ-ийг илүү тооцон шилжүүлсэнтэй холбоотой 779.7 мянган төгрөгийн шимтгэлийн авлага үүсгэсэнд төлбөрийн акт тогтоолоо.
- Хотонт сумын СХС тайлант онд олгосон 139.0 сая төгрөгийн олгосон зээлийг үр дүнгийн тайланд зардлаар бүртгэснийг аудитын явцад авлагаар бүртгүүлэн залруулга хийлгэлээ.
- Батцэнгэл сумын ТЕЗ ийн 3.7 сая төгрөгийн, Хангай сум ТЕЗ ийн 1.4 сая төгрөгийн авлага нь 15-22 жилийн насжилттай эзэн холбогдогчгүй, төлөгдөх боломжгүй зөрчилд данс бүртгэлээс хасахтай холбоотой арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүлсэн.
- Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн нийт 3,502.6 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулахад тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж, албан шаардлагыг сумдын ТЕЗ нарт хүргүүлээ.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал дансны эхний үлдэгдэл **5,779.3** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **7,078.3** сая төгрөг болж, **1,299.0** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	778.7	1,115.0	336.3
Эм боох материал	113.6	349.0	235.4
Дуусаагүй үйлдвэрлэл	79.9	0.0	(79.9)
Бэлэн бүтээгдэхүүн	1.1	1.5	0.4
Бичиг хэргийн материал	205.2	230.7	25.5
Аж ахуйн материал	3,544.3	4,154.1	609.8
Сэлбэг хэрэгсэл	141.7	144.1	2.4
Түлш шатах тослох материал	99.1	137.1	38.0
Барилгын засварын материал	164.9	225.9	61.0
Хүнсний материал	79.4	28.4	(51.0)
Бусад хангамжийн материал	174.9	350.5	175.6
Мал амьтад	272.2	261.6	(10.6)
Нөөцийн бараа	124.3	80.4	(43.9)

Дүн	5,779.3	7,078.3	1,299.0
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	5,612.2	6,912.5	1,300.3
Төсөл/сан	41.5	31.1	(10.4)
ОНӨҮГ	125.6	134.7	9.1
Дүн	5,779.3	7,078.3	1,299.0

Эх сурвалж: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын 97.7 хувь буюу 6,912.5 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 0.4 хувь буюу 31.1 сая төгрөгийг төсөл сангийн, 1.9 хувь буюу 134.7 сая төгрөгийг ОНӨҮГ-ын бараа материал тус тус эзэлж байна.

Тайлант онд бараа материал нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 7,690.3 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 990.1 сая төгрөг, шилжүүлэн авсан 359.2 сая төгрөг, бусад эх үүсвэрээс авсан 647.1 сая төгрөг нийт 9,686.7 сая төгрөгөөр нэмэгдэн, үйл ажиллагаанд зарцуулсан 7,943.8 сая төгрөг, бараа материалын шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр бусдад шилжүүлсэн 53.9 сая төгрөг, малын нас дэвшил болон акталж устгасан зэрэг бусад байдлаар 390.0 сая төгрөг нийт 8,387.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар Бараа материалын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Өндөр-Улаан, Батцэнгэл, Жаргалант сумдын ЕБС-ууд нь бараа материалын дэлгэрэнгүй тайланд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн нийт 10.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас зөвлөмж хүргүүллээ.
- Жаргалант сумын Хоолт багийн бага сургууль, Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12-р цэцэрлэг, Чулуут сумын ЭМТ-үүд нь 2020 оны төлөвлөсөн зардлаас хүнсний материал нөөцөлж, зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй нийт 3.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас төлбөрийн акт тогтоолоо.
- Хангай сумын Хүүхдийн цэцэрлэгийн нярав хүнсний материал дутагдуулсан 3.4 сая төгрөгийн, хүнсний материал нөөцөлж, зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй 0.3 сая төгрөгийн нийт 3.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас төлбөрийн акт тогтоолоо.
- БОАЖГ, Чулуут сумын ЭМТ, Батцэнгэл, Булган, Төвшрүүлэх сумдын Хүүхдийн цэцэрлэгүүд нь 2020 оны төлөвлөсөн зардлаас түлш шатах тослох материал нөөцөлж, зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй нийт 5.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.
- Булган сумын сургууль 7.6 сая төгрөгийн 188 толгой малын нэг тус бүрийн үнийг малын зах зээлийн дундаж үнээс 2-3 дахин багаар үнэлж хөрөнгө бүртгэлд тусгасан зөрчил илэрсэнд аудитаас зөвлөмж хүргүүллээ.
- Жаргалант сумын ЗДТГ-т бодитоор оршин байхгүй, анхан шатны баримт бүртгэл тооцоогүй мал амьтдыг бүртгэл тайланд тусгасан 9.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас албан шаардлага хүргүүллээ.
- Хотонт сумын ИТХ нь няравын тайлан тооцоо гаргаагүй, санхүүгийн программд түлш шатахууныг бөөн дүнгээр орлогод авч, бөөн дүнгээр зарлагадсан 11.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас албан шаардлага хүргүүллээ.
- Тариат сумын ИТХ нь бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан 0.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас зөвлөмж хүргүүллээ.
- Төвшрүүлэх сумын Соёлын төвийн бараа материалын модруулга тайлан дахь аж ахуйн материал, түлш шатах тослох материал, бусад хангамжийн материалын үлдэгдлүүд бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл болон тооллогын бүртгэлээс

зөрүүтэй тайлагнасан 9.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас албан шаардлага хүргүүлээ.

- Мөн аудитын явцад сумдын 14 төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланд бараа материалтай холбоотой 102.4 сая төгрөгийн залруулга хийгдлээ.
- Цөм сүргийн үржлийн төв ӨНӨҮГ нь санхүүгийн тайланд 86.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй бусад эргэлтийн хөрөнгийг биологийн хөрөнгөнд бүртгээснийг залрууллаа.

3.5.4 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ:

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл **15,495.9** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **382.0** сая төгрөг болж, 15,113.9 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- ✓ Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 415 дугаар тушаалын 6 дугаар зүйлийн 6.1-д “...барилга байгууламжийг барьж дуусах хүртэл,...**захиалагч байгууллага** эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана” гэсэн заалтын дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын хөрөнгө оруулалтын тайланд тусгагдсан аймгийн ОНӨГ-т давхардуулан бүртгэсэн 14 нэр төрлийн 14,819.3 сая төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгийг БШУЯ-наас 2020 оны 12 сарын 24-ны өдрийн 12/3678 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу данснаас хассан,
- ✓ Жаргалант сумын ЕБС-ийн тайланд бүртгэлтэй 273.1 сая төгрөгийн сургуулийн дотуур байрны засвар бүрэн дуусч барилга байгууламж дансанд шилжүүлсэн,
- ✓ Цөм сүрэг үржлийн төвийн 1 жилээс дээш хугацаатай авлага 21.5 сая төгрөгөөр буурсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тайлант онд ашиглалтанд ороогүй, он дамжин хэрэгжиж байгаа 381.9 сая төгрөгийн дараах хөрөнгүүд бүртгэлтэй байна. Үүнд:

- Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж 136.1 сая төгрөг
- 19 сумдад авсан бог малын арьс боловсруулах тоног төхөөрөмж 159.8 сая төгрөг
- Аймгийн Цөм сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ-ын 1 жилээс дээш хугацаатай авлага 86.0 сая төгрөгийн хөрөнгө тус тус бүртгэлтэй байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл **170,272.9** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **194,475.1** сая төгрөг болж **24,202.2** сая төгрөгөөр өссөн байна.

Нийт үндсэн хөрөнгийн 95.8 хувь буюу **186,276.1** сая төгрөгийг биет хөрөнгө, 4.1 хувь буюу **8,007.0** сая төгрөгийг биет бус хөрөнгө, 0.1 хувь буюу **192.0** сая төгрөгийг бусад хөрөнгө тус тус эзэлж байна.

Хүснэгт №8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	162,179.7	186,276.1	24,096.4
Биет бус хөрөнгө	7,932.7	8,007.0	74.3
Бусад хөрөнгө	160.5	192.0	31.5
Дүн	170,272.9	194,475.1	24,202.2
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	153,981.9	177,329.7	23,347.8
Төсөл/сан	181.5	251.7	70.2
ОНӨҮГ	16,109.5	16,893.7	784.2
Дүн	170,272.9	194,475.1	24,202.2

Нийт үндсэн хөрөнгийн 91.2 хувь буюу **177,329.7** сая төгрөгийг төсөвт байгууллагын, 0.1 хувь буюу **251.7** сая төгрөгийг төсөл сангийн, 8.7 хувь буюу **16,893.7** сая төгрөгийг ОНӨҮГ-ын үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 831.9 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 11,205.2 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 17,449.1 сая төгрөг, бусад эх үүсвэрээс авсан 15,365.1 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 0.2 сая төгрөг нийт 44,851.5 сая төгрөгөөр нэмэгдэн, балансаас баланст шилжүүлсэн 9,860.6 сая төгрөг, акталсан 7,383.3 сая төгрөг, бусад 180.1 сая төгрөг нийт 17,424.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

Биет хөрөнгөнд дансанд бүртгэлтэй байгаа Дуусаагүй барилга байгууламж дансанд 4,574.9 сая төгрөгийн дараах үндсэн хөрөнгүүд байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн 3,584.4 сая төгрөгийн өртөгтэй Тариат сумын “Сумын төвийн шинэчлэл”-ийн ажил дууссан боловч ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, 200.0 сая төгрөгийн өртөгтэй “Ахуй үйлчилгээний төв” бүртгэлтэй байснаас тайлант онд гүйцэтгэгч байгууллага “Зориг конструктор” ХХК-тай холбоотой Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 02 сарын 03-ны өдрийн 175 тоот, 2018 оны 01 сарын 04-ны өдрийн 34 тоот шүүгчийн захирамжийг үндэслэн 82.2 сая төгрөгийг данснаас хасч 117.8 сая төгрөгийн бодит гүйцэтгэлээр бүртгэлд тусгасан нийт 3,702.2 сая төгрөгийн дуусаагүй барилгууд нь Аймгийн ОНӨГ-т бүртгэлтэй байна.
2. Сумын ОНХС-аас санхүүжигдсэн 58.0 сая төгрөгийн Халуун усны барилга, аймгийн ОНХС-аас санхүүжигдсэн 6.6 сая төгрөгийн худаг нийт 64.6 сая төгрөгийн хөрөнгө 2016 оноос хойш Хангай сумын ЗДТГ-т, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн 550.0 сая төгрөгийн 75 хүүхдийн дотуур байрны барилга 2015 оноос хойш Хангай сумын ЕБС-ийн дансанд бүртгэлтэй байна.
3. Орон нутгийн ерөнхий орлогын давсан орлогоос санхүүжигдсэн 218.6 сая төгрөгийн ЗДТГ-ын барилга 2019 оноос хойш Жаргалант сумын ЗДТГ-т бүртгэлтэй байна.
4. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн 25.3 сая төгрөгийн эхчүүдийн амрах байр 2017 оноос хойш Төвшрүүлэх сумын ЭМТ-д бүртгэгдсэн байна.
5. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн 14.1 сая төгрөгийн сумын төвийн худаг 2015 оноос хойш Цахир сумын ЗДТГ-т тус тус бүртгэлтэй байна.

Биет бус хөрөнгө дансанд 208.2 сая төгрөгийн програм хангамж, 7,926.1 сая төгрөгийн бусад биет бус хөрөнгө бүртгэлтэй байна. Нийт хуримтлагдсан элэгдэл 127.3 сая төгрөг байна.

Бусад хөрөнгө дансанд Цөм сүрэг үржлийн төвийн 176.2 сая төгрөгийн биологийн хөрөнгө буюу мал, Хангай сумын ЗДТГ-ын 15.7 сая төгрөгийн хүндэтгэлийн хаалга нийт 191.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Нийт 55 төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгийн дансанд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 3,400.4 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил илэрсэнд аудитаас зөвлөмж хүргүүлээ.

- Төсөвт байгууллагуудад ашиглагдаж байгаа тус бүр нь 1,200.0 мянган төгрөгийн өртөгтэй СИ ТИ ЭС санхүүгийн программыг Цэцэрлэг, Цэнхэр, Тариат, Жаргалант, Хотонт сумдын ЗДТГ-ын бүртгэл тайланд тусгасан 8.4 сая төгрөгийн, бүртгэл тайланд огт тусгаагүй 1.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас зөвлөмж хүргүүлээ.
- Ихтамир болон Өгийнуур сумын ЕБС-ууд нь БШУС-ын 2017 оны 40 дүгээр тушаалаар баталсан харьяа байгууллагуудад ашиглагдах НБББББ-ын баримт бичгийн 2 дугаар хавсралтаар баталсан үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоход баримтлах хугацааг хөрөнгийн материал, шинж чанараар нь харилцан адилгүй тогтоосон байхад сургуулийн бүх тавилга, эд хогшлыг 10 жилээр, техник тоног төхөөрөмжийг 5 жилээр элэгдэл тооцох хугацааг тогтоосон зөрчилд аудитаас зөвлөмж хүргүүлээ.
- Өгийнуур сумын ЗДТГ нь шинээр нэмэгдсэн 302.6 сая төгрөгийн 14 хөрөнгийн элэгдүүлэх хугацаа нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсантай уялдаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлээ.
- Булган сумын ЕБС нь БШУЯ-аас үнэ төлбөргүй олгосон 1.4 сая төгрөгийн сурах бичиг, дунд, ахлах ангийн 51 багц 1.1 сая төгрөгийн түрээсийн сурах бичгийг бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан зөрчилд аудитаас зөвлөмж хүргүүлээ.
- Өлзийт сумын ЕБС нь БШУЯ-аас шилжүүлэн өгсөн 2.6 сая төгрөгийн түрээсийн сурах бичгийг бүртгэл тайланд тусгаагүй байна. Мөн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд өмнөх онуудад БШУЯ-аас шилжүүлэн өгсөн 13,541.3 мянган төгрөгийн сурах бичиг, номыг нэг бүрийн үнэ, тоо ширхгээр бүртгээгүй бөөн дүнгээр бүртгэсэн зөрчилд аудитаас зөвлөмж хүргүүлээ.
- Орон нутгийн өмчийн газар-т Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 20-р тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ыг зөрчиж өөрийн үндсэн үйл ажиллагаанд хамаарахгүй 8,109.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг шилжүүлэн авч бүртгэлд тайланд тусгасан, төсвийн хөрөнгөөр бэлтгэж иргэдэд эзэмшүүлсэн 821.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасч тайлагнасан нийт 8,931.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас албан шаардлага хүргүүлээ.
- Төвшрүүлэх сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй нийт 76,743.5 мянган төгрөгийн хөрөнгийг бөөн дүнгээр бүртгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Ар Ус Ундарга ХХК нь тайлант жилд байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 8,109.7 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг Аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын тогтоол шийдвэргүйгээр Орон нутгийн өмчид шилжүүлэн бүртгүүлсэн зөрчлүүд илэрсэнд аудитаас албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.
- Эрдэнэбулган сумын 1-р сургууль, Өндөр-Улаан сумын Хануйн бага сургууль, Ихтамир сумын ЗДТГ, Төвшрүүлэх сумын ЭМТ, Тариат сумын ЗДТГ, Булган сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгөтэй холбоотой 1,132.2 сая төгрөгийн залруулга хийгдлээ.
- Ар Ус Ундарга ХХК нь Азийн хөгжлийн банкны шугамаар гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлийн хүрээнд хоногт 3000м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай 7,679.5 сая төгрөгийн өртөг бүхий 24-н нэр төрлийн барилгыг хүлээн авсан боловч бүртгэл тайланд тусгаагүй байсныг аудитын явцад бүртгэл тайланд тусгуулж залрууллаа.

3.5.6 ӨР ТӨЛБӨР

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл **7,400.3** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **12,407.9** сая АРА-2021/01/СТА-ТЕЗ

төгрөг болж, **5,007.6** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.9 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	5,171.3	1,236.9	(3,934.4)
Богино хугацаат зээлийн өглөг	0.0	5.1	5.1
Өглөг	5,136.8	1,191.2	(3,945.6)
Ажилчидтай холбогдсон өглөг	26.1	11.1	(15.0)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.3	0.4	0.1
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	4,422.9	299.1	(4,123.8)
Бусад өглөг	687.5	880.6	193.1
Байгууллагад төлөх өглөг	668.5	851.2	182.7
Хувь хүмүүст төлөх өглөг	11.8	0.5	(11.3)
Татварын өглөг	6.5	27.2	20.7
НДШ-ийн өглөг	0.7	1.7	1.0
Урьдчилж орсон орлого	34.5	40.6	6.1
Урт хугацаат өр төлбөр дүн	2,229.0	11,171.0	8,942.0
Урт хугацаат зээл	2,229.0	11,171.0	8,942.0
Дүн	7,400.3	12,407.9	5,007.6
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	693.9	854.6	160.7
Төрийн сан	15.7	20.8	5.1
ОНӨҮГ	6,690.7	11,532.5	4,841.8
ДҮН	7,400.3	12,407.9	5,007.6

Эх сурвалж: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 6.9 хувийг төсөвт байгууллагын, 92.9 хувийг ОНӨҮГ-ын, 0.2 хувийг төсөл сангийн өр төлбөр эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 5,171.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,236.9 сая төгрөг болж 3,934.4 сая төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өр төлбөрийн 69.1 хувь буюу 854.6 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 1.7 хувь 20.8 сая төгрөгийг төсөл сан, 29.2 хувь буюу 361.5 сая төгрөгийг ОНӨҮГ-ууд тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагын өр төлбөр

- ✓ Төсөвт байгууллагын өр төлбөрийн 97.2 хувь буюу 830.9 сая төгрөг нь нэгдсэн халаалтын өр байна. Үүнд: Тариат сумын ЕБС- 275.1 сая төгрөг, соёлын төв- 9.9 сая төгрөг, Өлзийт сумын ЕБС - 442.3 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг-26.9 сая төгрөг, соёлын төв -76.7 сая төгрөг тус тус байна.

ОНӨГ-ын өр төлбөр

- ✓ Аймгийн ЦСҮТ ОНӨҮГ нь 3.4 сая төгрөгийн татварын өглөгтэй ажилласан.
- ✓ “Архангайд үйлдвэрлэв” ОНӨҮГ нь 0.2 сая төгрөгийн цалингийн өглөг, 3.2 сая төгрөгийн Ар Ус Ундарга ХХК-д төлөх өглөг, 19.9 сая төгрөгийн татварын өглөг, 23.6 сая төгрөгийн урьдчилж орсон түрээсийн барьцаа нийт 46.9 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

- ✓ “Ар Ус Ундарга” ХХК ОНӨҮГ-ын 304.5 сая төгрөгийн өр төлбөрийн 0.8 сая төгрөг нь байгууллагад төлөх өглөг, 3.3 сая төгрөг нь татварын өглөг, 1.3 сая төгрөг нь урьдчилж орсон орлого байна. Тайлант онд татварын өр 2.9 сая төгрөгөөр буурсан. Харин “хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг” тайлант онд 299.1 сая төгрөгөөр тайлагнагдаж өмнөх оноос 4,123.8 сая төгрөгөөр буурсан нь тухайн компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 8,109.7 сая төгрөгийн өртөг бүхий 45-н нэр төрлийн барилга, байгууламж, цэвэр бохир усны шугам хоолойг аймгийн ОНӨГазарт шилжүүлж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.
- ✓ Чулуутын ахуй үйлчилгээний төв нь 2 байгууллагад төлөх 4.5 сая төгрөгийн түлш халаалтын өр, 0.5 сая төгрөгийн татварын өр, 1.7 сая төгрөгийн НДШ-ийн өр нийт 6.8 сая төгрөгийн өр төлбөртэй ажилласан байна.

Төрийн сангийн өр төлбөр

- ✓ Бусад урьдчилж орсон орлогын 15.7 сая төгрөг нь татварын цахим систем шинэчлэгдсэнтэй холбогдон данс андуурч Эрдэнэмандал сумын ерөнхий орлогын дансанд 2019 онд төвлөрсөн мөнгө одоог хүртэл үлдэгдэлтэй санхүүгийн тайланд бүртгэлтэй байна гэсэн тайлбарыг сумын засаг даргаас ирүүлсэн байна.
- ✓ ҮАГ-аас өгсөн албан шаардлагын дагуу “Хөдөөгийн ядуурлыг бууруулах төсөл”-ийн нэгжээс иргэдэд олгосон 52.1 сая төгрөгийн зээлээс 47.0 төгрөгийг барагдуулж, 5.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгааг Аймгийн ерөнхий орлогын дансанд тайлагнасан байна.

Урт хугацаат өр төлбөр

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан “Ар Ус Ундарга” ХХК ОНӨҮГ-ийн урт хугацаат өр төлбөр нь 11,171.0 сая төгрөг болж 8,941.9 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Монгол улсын Сангийн яам болон Архангай аймгийн Засаг даргын тамгын газрын хооронд байгуулсан Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний дагуу олгогдсон зээлийн үлдэгдэл байна.

Урт хугацаат зээлийг задалж харуулбал:

- 2004-2010 онуудад хэрэгжсэн нийтийн аж ахуйг сайжруулах 2 үе шаттай төслийн хүрээнд хэрэгжсэн 2,110.7 сая төгрөгийн зээл /Архангай аймгийн ЗДТГазар OL-1907MON-08 зээлийн гэрээний дугаартай/.
Тус зээл нь 2010-2028 оны хооронд төлж дуусахаар байгаа бөгөөд одоог хүртэл төлөлт хийгдээгүй хэвээр байна.
- 2016 онд нийлүүлэгдсэн 118.3 сая төгрөгийн бохирын машины зээл /Архангай аймгийн ЗДТГазар OL-2301MON-1 зээлийн гэрээний дугаартай/.
- “Аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ” ажлын хүрээнд 7,679.5 сая төгрөгийн өртөг бүхий 24-н нэр төрлийн барилга барих, холбогдон гарсан 1,262.4 сая төгрөгийн зардал нийт 8,941.9 сая төгрөгийн зээл /Архангай аймгийн ЗДТГазар OL3388MON-1 зээлийн гэрээний дугаартай/

Аудитын илрүүлэлт

- Тариат сумын ЕБС нь өмнөх оны аудитаар өгсөн өр төлбөрийг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй буюу тайлан оны эцэст халаалтын өр 275.1 сая төгрөг болж өмнөх оноос 73.4 сая төгрөгөөр өссөнд аудитаас зөвлөмж хүргүүлээ.
- Төвшрүүлэх сумын ЭМТ нь 3 албан хаагчийн сахилгын шийтгэлийн дүнг орон нутгийн дансанд төвлөрүүлээгүй, Ази фарм ХХК-д эм бэлтгэн нийлүүлсэн өмнөх оны үлдэгдэл өр төлбөрийг барагдуулаагүйтэй холбоотой 1.1 сая төгрөгийн өглөгийн тооцоо үүсгэсэн зөрчилд аудитаас албан шаардлага хүргүүлээ.

- Эрдэнэбулган сумын ЗДТГ нь байгууллагад төлөх 9.6 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зөрчил илэрсэнд аудитаас албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

3.5.7 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл **201,360.7** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **208,669.6** сая төгрөг болж, **7,308.9** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №10 Цэвэр хөрөнгө өмчийн дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/
Засгийн газрын хувь оролцоо	201,360.7	208,669.6	7,308.9
Засгийн газрын оруулсан капитал	60,845.5	62,185.4	1,339.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,395.6	3,414.9	19.3
Хуримтлагдсан үр дүн	87,094.0	96,927.1	9,833.1
Өмнөх үеийн үр дүн	69,540.5	93,693.9	24,153.4
Тайлант үеийн үр дүн	17,553.5	3,233.2	(14,320.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,025.6	46,142.2	(3,883.4)
Дүн	201,360.7	208,669.6	7,308.9
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	183,994.3	192,566.9	8,572.7
Төсөл, сан	4,016.1	3,242.0	(774.2)
Төрийн сан	3,141.0	6,743.3	3,602.3
ОНӨҮГ	10,209.3	6,117.4	(4,091.9)
Дүн	201,360.7	208,669.6	7,308.9

Эх сурвалж: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал 2019 оны эцэст 60,845.5 сая төгрөг байсан бол тайлант онд 62,185.4 сая төгрөг болж, 1,339.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь “Чулуут ахуйн үйлчилгээний төв” ОНӨҮГ шинээр байгуулагдаж, аймгийн мал хамгаалах сан шинээр газар бүртгэсэнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн өмнөх оноос 9,833.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 3,233.2 сая төгрөгөөр, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 6,598.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд 6,598.8 сая төгрөгөөр бичилт хийгдсэнийг задалж авч үзвэл:

- Ар-Ундарга ХХК нь Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэргүйгээр үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 8,109.7 сая төгрөгийн өртөг бүхий 45-н нэр төрлийн барилга, байгууламж, цэвэр бохир усны шугам хоолойг аймгийн ОНӨГазарт шилжүүлж данснаас хассантай холбоотой 4,653.2 сая төгрөгөөр, Азийн хөгжлийн банкны төслийн зээлээр хэрэгжсэн “Аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ” ажлын хүрээнд 7,679.5 сая төгрөгийн өртөг бүхий 24-н нэр төрлийн барилгыг орлогод авч, холбогдон гарсан зардал 1,262.4 сая төгрөгөөр тус тус бичилт хийсэн байна.
- Зарим төсөвт байгууллагууд дахин үнэлгээ хийгдсэн үндсэн хөрөнгө акталсантай холбоотой 788.3 сая төгрөгийн бичилт хийгдсэн.
- “Чулуут ахуйн үйлчилгээний төв” нь хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг шилжүүлж авсантай холбоотойгоор 105.1 сая төгрөгөөр бууруулах бичилт хийгдсэн байна.

Дахин үнэлгээний нөөц данс нь өмнөх оноос 3,883.4 сая төгрөгөөр буурсан нь:

- Ар-Ундарга ХХК Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэргүйгээр дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгийг аймгийн ОНӨГазарт шилжүүлж данснаас хассантай холбоотой 3,078.7 сая төгрөг,
- Төсөвт байгууллагууд дахин үнэлгээ хийгдсэн үндсэн хөрөнгө акталж шилжүүлсэнтэй холбоотой 804.7 сая төгрөгөөр тус тус бичилт хийсэнтэй холбоотой байна.

3.7 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн ТЕЗ нь шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 140 мэдээллээс 79 мэдээллийг хугацаанд нь, 61 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Аудитын илрүүлэлт

ОНТЕЗ-ийн харьяа төсвийн шууд захирагчийн 156, сумын ТЕЗ-ийн 19, ОНӨҮГ-4 нийт 179 байгууллагуудын шилэн дансны мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Төсвийн шууд захирагчийн шилэн дансны талаар: 84 байгууллагатай холбоотой нийт 1519 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 619.4 сая төгрөгийн 186 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс 57 албан шаардлага, 27 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.
2. Сумын ТЕЗ-ийн шилэн дансны талаар: 11 сумын ТЕЗ-тай холбоотой нийт 293 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 254.6 сая төгрөгийн 19 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрсэнд аудитаас зөрчлийг арилгуулж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах, 3 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах нийт 8 албан шаардлага, 5 зөвлөмжийг тус тус хүргүүлээд байна.
3. ОНӨҮГ-ын шилэн дансны талаар: Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ, Архангайд үйлдвэрлэв ОНӨҮГ-ууд нь Шилэн дансны цахим хуудсанд бүртгэлгүй, мэдээлэл байршуулдаггүй, Ар Ус Ундарга ХХК нь 36 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зэрэг зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах 3 албан шаардлагыг хүргүүлээ.

Дээрх зөрчлүүдээс үзэхэд аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагын 55.0 хувь буюу 98 байгууллагад шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроон мэдээлэх зөрчил давамгайлж байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах шаардлагатайг харуулж байна.

3.8 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Аймгийн СТСХ-ийн даргын 2020 оны 12 сарын 07-ны өдрийн 08/1358 тоот, ОНӨГ-ын даргын 2020 оны 06 сарын 19-ны 379 тоот, 2020 оны 12 сарын 23-ны өдрийн 682 тоот, 2020 оны 12 сарын 04-ны өдрийн 618 тоот, 2020 оны 12 сарын 01-ны өдрийн 604 тоот, 2020 оны 12 сарын 22-ны өдрийн 672 тоот албан бичгүүдээр ОНТЕЗ-ийн өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хариуг ирүүлсэн байна. Үүнийг үнэлж үзэхэд хэрэгжилт 50%-тай байна гэж үзлээ.

Хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

№	Зөвлөмж, албан шаардлагын агуулга	Биелэлт	Хэрэгжилтийн байдал
1	ОНХС-аас санхүүжигдсэн 147,854.2 мянган төгрөгийн өвөл, зуны хүлэмж, хүнсний ногоо боловсруулах тоног төхөөрөмжийг Аймгийн ОНӨГ-ын бүртгэл тайланд бүрэн тусгах, Цаашид зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.	100%	Аймгийн ОНХС-аас санхүүжигдсэн өвөл зуны хүлэмжийг аймгийн ОНӨГ-ын бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.
2	УСНББОУС болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулахад Аймгийн СТСХ санаачлага гарган ажиллах	50%	Аймгийн СТСХ-ийн даргын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 08/1365 тоот “2021 оны төсөв батлуулахад анхаарах асуудал, баримтлах чиглэлийн тухай” албан бичгийн 2.2-т “Сумын ЗДТГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг хийлгэх зардлыг хичээл үйлдвэрлэлийн зардалд тусгах” чиглэлийн дагуу сумдын ЗДТГ-т тодорхой хэмжээний зардал төлөвлөн батлуулж, хэрэгжилт нь 2021 онд биелэгдэхээр байна.
3	Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, өр төлбөрийг барагдуулахад Аймгийн ТЕЗ-ийн зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллах, цаашид шинээр өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч, сумдын удирдлагуудад үүрэг чиглэл өгч ажиллах	50%	Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн төсөвт зохицуулалт хийх хурлын тогтоолоор ЕБС-ийн хэмнэгдэж буй тогтмол зардлаас Тариат, Эрдэнэмандал, Өлзийт сумдын ЕБС-ийн халаалтын өрөнд 99.9 сая төгрөг, Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгүүдийн халаалтын өрөнд 23.1 сая төгрөг тус тус шилжүүлж нийт 123.0 сая төгрөгийн зохицуулалт хийж шийдвэрлэсэн байна.
4	Аймгийн ТЕЗ-ийн зүгээс ОНӨҮГ-уудын үйл ажиллагаанд судалгаа хийж үр дүнтэй ажиллах чадавхид үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид ОНӨҮГ-уудын үр дүн, ашигт ажиллагааг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах	0	“Аялал жуулчлал, мэдээлэл үйлдвэрлэлийн төв” нь үйл ажиллагаа явуулаагүй, газрын хөрөнгийг аймгийн Засаг даргын захирамжаар БОАЖГ-т шилжүүлсэн байна. Ар Ус Ундарга ХХК, Цөм сүргийн үржлийн төв, Архангайд үйлдвэрлэв ОНӨҮГ-уудын ашигт ажиллагааг дээшлүүлэхийн тулд тус газруудын бизнес төлөвлөгөөг батлуулан, аймгийн ОНХС-аас тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэн, аймгийн ОНӨГ-аас үйл ажиллагаанд хяналт тавьж, үр ашигтай ажиллуулах талаар хуулийн хүрээнд дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилласан байна.
Хэрэгжилт дутуу зөвлөмжийн тоо		2	50%

Хэрэгжилтийн байдлаас харахад өр төлбөрийг барагдуулахад тодорхой арга хэмжээ авч ажилласан боловч тайлант онд Тариат, Өлзийт сумдын халаалтын өр 180.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байгаа тул зөвлөмжийн биелэлтийг 50%-тай гэж үзлээ.

Харин ОНӨҮГ-уудын үйл ажиллагаанд хяналт тавьж, үр ашигтай ажиллуулах талаар дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа боловч эдгээр нь алдагдалтай ажиллаж, санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилтэй санал дүгнэлт авч, алдаа зөрчил буурахгүй байгаа тул зөвлөмжийн биелэлт хангагдаагүй байна гэж үзлээ.

3.9 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд түүний харьяа 156 төсвийн байгууллага, 4 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 41 орон нутгийн тусгай сан, 19 сумын ТТЗ нийт 220 санхүүгийн тайланг нэгтгэсэн бөгөөд аймгийн засаг дарга данс, түүний хөтөлбөр арга хэмжээ, барьцаа хөрөнгө, техник хяналтын зардлын дансдын гүйлгээ хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хийсэн аудитаар 220 байгууллагын санхүүгийн тайлан хамрагдсанаас 12 тайланд итгэл үзүүлэн, 78 тайланг түүвэрт хамруулан шалгаж, 130 төсөв захирагчийн тайланд санал дүгнэлт хүргүүлээ. Хүснэгтээр харуулбал:

Байгууллагын төрөл	Байгууллага нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийлгээгүй				
Төсвийн шууд захирагч	156	106	38	12	0	95	10	0	1
Төсөл сан	41	1	40			1			
Сумдын ТТЗахирагч	19	19				18	1		
ОНӨҮГГазар	4	4					3		1
Нийт	220	130	78	12	0	114	14	0	2

Аудитад хамрагдсан төсөв захирагчдын 114 тайланд “Зөрчилгүй”, 14 тайланд “Хязгаарлалттай”, 2 тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлтийг өгсөн байна.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 30.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах, таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүлэн, 2 зөрчилтэй асуудалд зөвлөмж өгч ажиллалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

- 2017 онд аймгийн засаг даргын хөтөлбөр арга хэмжээний зардлаас Хайрхан сумын малчин О.Доржтой шилмэл үүлдрийн хээлтүүлэгч бог малын үүлдэр угсааг сайжруулах төсөл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан 20.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх

нөхцөлтэйгээр олгосон бөгөөд 2018 оны 10-р сард малчин О.Доржийн хүсэлтийн дагуу 2018, 2019, 2020 онуудад шилмэл омгийн хуц нийлүүлэн зээлийг төлж барагдуулах өөрчлөлтийг оруулсан боловч гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, авлага барагдаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэхь заалт, Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны а/95 дугаар тушаалаар баталсан төлбөрийн акт, албан шаардлага өгөх журам"-ын 4.2.1.11 дэхь заалтыг үндэслэн зөрчлийг зөрчлийг арилгаж, авлагыг барагдуулах албан шаардлагыг хүргүүллээ.

2. Аймгийн мал хамгаалах сангийн тайланд тусгагдсан 10.9 сая төгрөгийн авлагын 3.9 сая төгрөг нь 2013-2016 онуудад , 7.1 сая төгрөг нь 2018 онд үүссэн хувь хүнээс авах өвс тэжээлийн 2-7 жилийн насжилттай авлагын тооцоо бөгөөд 2020 онд эдгээр авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэхь заалт, Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны а/95 дугаар тушаалаар баталсан төлбөрийн акт, албан шаардлага өгөх журам"-ын 4.2.1.11 дэхь заалтыг үндэслэн зөрчлийг зөрчлийг арилгаж, авлагыг барагдуулах албан шаардлагыг хүргүүллээ.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 140 мэдээллээс 61 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зөрчил илэрлээ.Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.10 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэхь заалт, Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны а/95 дугаар тушаалаар баталсан төлбөрийн акт, албан шаардлага өгөх журам"-ын 4.2.1.11 дэхь заалтыг үндэслэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

ОНТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт **28,694.7** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад **9,408.2** сая төгрөгийн алдааг залруулж, **73.1** сая төгрөгийн зөрчилд 44 төлбөрийн акт тогтоож, **10,670.4** сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 139 албан шаардлага хүргүүлэн, **8,543.0** сая төгрөгийн зөрчилд 273 заалт бүхий зөвлөмж өгч ажилласан байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 67.2 хувь залруулагдаагүй алдаа зөрчил, 32.8 хувь нь залруулагдсан алдаа байна.

2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитад 19 сумын ТТЗ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан хамрагдсанаас 18 сумын нэгтгэсэн тайланд "Зөрчилгүй", Хашаат сумын ТТЗ-ийн нэгтгэсэн тайланд "Хязгаарлалттай" санал дүгнэлтийг хүргүүллээ.

Аудитаар нийт **4,133.8** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 160.9 сая төгрөгийн алдааг залруулж, 648.1 сая төгрөгийн зөрчилд 22 албан шаардлага, зөрчил гаргасан 4 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэн, 3,324.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 35 зөвлөмж өгч ажиллалаа.

3. Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Аудитад 156 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан хамрагдсанаас 12 тайланд итгэл үзүүлэн, 38 тайланг түүвэрт хамруулан шалгаж, 106 төсөв захирагчийн тайланд санал дүгнэлт хүргүүллээ.

Аудитаас санал дүгнэлт хүргүүлсэн 95 төсөв захирагчийн тайланд “Зөрчилгүй”, 10 төсөв захирагчийн тайланд “Хязгаарлалттай”, 1 төсөв захирагчийн тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” байна.

Хязгаарлалттай болон санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дараах байгууллагууд байна.

№	Байгууллагын нэр	Дүгнэлтийн төрөл
1	Аймгийн ИТХ	Хязгаарлалттай
2	Орон нутгийн өмчийн газар	Хязгаарлалттай
3	Жаргалант сумын ЗДТГ	Хязгаарлалттай
4	Цэцэрлэг сумын ЗДТГ	Хязгаарлалттай
5	Эрдэнэбулган сумын ИТХ	Хязгаарлалттай
6	Хотонт сумын ИТХ	Хязгаарлалттай
7	Хашаат сумын ИТХ	Хязгаарлалттай
8	Өлзийт сумын ЕБС	Хязгаарлалттай
9	Тариат сумын ЕБС	Хязгаарлалттай
10	Өлзийт сумын ЭМТ	Хязгаарлалттай
11	Өлзийт сумын ЗДТГ	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан

ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт **16,574.7** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 1,370.6 сая төгрөгийн алдааг залруулан, 73.1 сая төгрөгийн зөрчилд 44 төлбөрийн акт, 9,936.5 сая төгрөгийн зөрчилд 107 албан шаардлага, 5,194.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 231 зөвлөмжийг хүргүүллээ.

Мөн зөрчил гаргасан 4 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэн ажиллалаа.

4. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Аудитад 4 ОНӨҮГ-ын санхүүгийн тайлан хамруулан шалгаж, Ар- Ус Ундарга ХХК, Цөм сүрэг үржийн төв, Архангайд үйлдвэрлэв ОНӨҮГ-уудын санхүүгийн тайланд “хязгаарлалттай” санал дүгнэлт, Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨҮГ-ын санхүүгийн тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт хүргүүллээ.

Аудитаар нийт **7,986.2** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 7,876.7 сая төгрөгийн алдааг залруулан, 85.8 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 23.7 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгч ажиллалаа.

5. Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Аудитад 41 тусгай сангийн санхүүгийн тайлан хамрагдсанаас 40 тайланг түүвэрт хамруулан шалгаж, 1 тайланд санал дүгнэлт хүргүүллээ.

Аудитаар Халамжийн сангийн санхүүгийн тайланд аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт хүргүүлсэн бөгөөд аймгийн болон 19 сумын ОНХС, СХС-ийн санхүүгийн тайланг түүвэрт

хамруулан шалгаж, зөрчлийг сумын ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитад хамаарууллаа.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн нэгдсэн тайланд тусгагдсан төсөвт байгууллагуудын өр төлбөрийг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон ОНӨҮГ-уудын үйл ажиллагааны үр дүн, ашигт ажиллагаа, санхүүгийн тайлагналын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг шалгана.
2. Дараагийн шатны аудитаар дараах 2 асуудлыг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.Үүнд:

- Аймгийн ТЕЗ-ийн тайланд тусгагдсан 19 жилийн насжилттай эзэн холбогдогчгүй **46.3** сая төгрөгийн төрийн сангийн авлагыг барагдуулах талаар өмнөх жилүүдийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлэн, ҮАГ-т уламжилж байсан боловч шийдэгдээгүй байна.

Иймд найдваргүй авлагыг данс бүртгэлээс хасуулах талаар Сангийн яаманд уламжилж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

- Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд тусгагдсан нийт өр төлбөрийн 97.2 хувь буюу 830.9 сая төгрөг нь нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой Тариат болон Өлзийт сумдын ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдэд 2018-2019 онуудад үүссэн халаалтын өр байна. Өр үүссэн асуудалд аудитын байгууллагаас зөвлөмж, албан шаардлага хүргүүлж байсан боловч барагдаагүй бөгөөд тухайн өр төлбөрийг шийдвэрлүүлэхээр орон нутгаас жил бүр зардлын тооцоог төсвийн төсөлд тусгадаг боловч Сангийн Яам зардлыг өмнөх жилүүдийн түвшинд хянасаар байна.

Үүнээс үүдэж боловсролын байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдаж, улмаар хүүхдийн сурч боловсрох эрх ашиг зөрчигдөхөд хүрч болзошгүй болсон байна.

Иймд энэ асуудлыг Сангийн Яаманд уламжлан шийдвэрлэхэд санал гаргах нь зүйтэй байна.

4. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ Д.ЗОЛЖАРГАЛ, СТСХ-ИЙН ДАРГА Ж.МӨНХБАТ, ОНӨГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.ОЮУН-ЭРДЭНЭ НАРТ

4.1 ӨР ТӨЛБӨРИЙН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт

Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангаар төсөвт байгууллагуудын нийт өр төлбөр 854.6 сая төгрөгөөр тайлагнагдсан ба үүний 97.2 хувь буюу 830.9 сая төгрөг нь нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой Тариат болон Өлзийт сумын төсөвт байгууллагуудад үүссэн халаалтын өр байна. Үүнд:

- Тариат сумын ЕБС 275.1 сая төгрөг, соёлын төв 9.9 сая төгрөг болж өмнөх оноос нийт дүнгээр 76.6 сая төгрөгөөр,
- Өлзийт сумын ЕБС 442.3 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 26.9 сая төгрөг, соёлын төв 76.7 сая төгрөг болж өмнөх оноос нийт дүнгээр 103.3 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Эрсдэл

- Төсвийн тухай хууль зөрчигдөх
- Байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмж буурах
- Боловсролын байгууллагын хувьд сургалт явуулах орчин нөхцөл бүрдэхгүй байх

Зөвлөмж

- Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, өр төлбөрийг барагдуулах талаар Аймгийн ТЕЗ-ийн зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллах
- Цаашид шинээр өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч, сумдын удирдлагуудад үүрэг чиглэл өгч ажиллах

4.2 ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ААН-ҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт:

Орон нутгийн өмчит ААН-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 4 хуулийн этгээд хамрагдаж, “Ар-Ус Ундарга” ОНӨХХК, “Архангайд үйлдвэрлэв” болон Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ-ууд нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт, харин “Чулуут ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-т “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлтийг авсан. Аудитаар нийт 7, 986.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- ОНӨҮГ-ууд нь санхүүгийн тайлангаа Сангийн Сайдын 361-р тушаалын дагуу үнэн зөв стандартын дагуу тайлагнаагүй, үндсэн хөрөнгө, бараа материал, орлого зарлагыг дутуу тусгаж, орхигдуулснаас үүдэн 7,876.7 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдсэн,
- Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэргүйгээр үндсэн хөрөнгийг данснаас хассан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, авлага, өр төлбөр үүсгэж, алдагдалтай ажилласан, орон тооны нягтлан бодогчгүй, нягтлан бодогчдын мэдлэг ур чадвар сул зэрэг зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, НББ-ийн тухай хуулиуд болон Сангийн сайдын 361-р тушаалыг зөрчсөн байна.

Эрсдэл:

- Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан зөрүүтэй илэрхийлэгдэх, улмаар аудитын санал дүгнэлтэнд нөлөөлөх
- Орон нутгийн төсөвт хүндрэл учруулах
- Орон нутгийн өмч хөрөнгө бүртгэлд тусгагдахгүй орхигдох

Зөвлөмж:

Аймгийн ТЕЗ-ийн зүгээс ОНӨҮГ-уудад дараах арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна. Үүнд:

- Хөрөнгө санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах
- Үйл ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж, ашигт ажиллагааг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах
- Санхүүгийн ажилтнуудын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах, сургах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах

Зөвлөмжийн биелэлт болон хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2021.12.01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.

Хавсралт

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр:	Архангай аймгийн ТЕЗ-ийн 2020 оны СТА	Аудитын код: APA-2021/01/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Архангай аймгийн ТЕЗ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2017 онд аймгийн засаг даргын хөтөлбөр арга хэмжээний зардлаас Хайрхан сумын малчин О.Доржтой шилмэл үүлдрийн хээлтүүлэгч бог малын үүлдэр угсааг сайжруулах төсөл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан 20.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон бөгөөд 2018 оны 10-р сард малчин О.Доржийн хүсэлтийн дагуу 2018, 2019, 2020 онуудад шилмэл омгийн хуц нийлүүлэн зээлийг төлж барагдуулах өөрчлөлтийг оруулсан боловч гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, авлага барагдаагүй байна	20.0	Албан шаардлага	Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ц.Мөнхнасан, Ж.Мөнхбат
2	Аймгийн мал хамгаалах сангийн тайланд тусгагдсан 10.9 сая төгрөгийн авлагын 3.9 сая төгрөг нь 2013-2016 онуудад, 7.1 сая төгрөг нь 2018 онд үүссэн хувь хүнээс авах өвс тэжээлийн 2-7 жилийн насжилттай авлагын тооцоо бөгөөд 2020 онд эдгээр авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.	10.9	Албан шаардлага	Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ц.Мөнхнасан, Ж.Мөнхбат
3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 140 мэдээллээс 61 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зөрчил илэрлээ.	-	Албан шаардлага	Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ц.Мөнхнасан, Ж.Мөнхбат
4	Орон нутгийн өмчит ААН-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 4 хуулийн этгээд хамрагдаж, "Ар-Ус Ундарга" ОНӨХХК, "Архангайд үйлдвэрлэв" болон Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ-ууд нь "Хязгаарлалттай" санал дүгнэлт, харин "Чулуут ахуйн үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-т "Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан" дүгнэлтийг авсан. Аудитаар нийт 7, 986.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн.	-	Зөвлөмж хүргүүлэх	Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ц.Мөнхнасан, Ж.Мөнхбат
5	Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангаар төсөвт байгууллагуудын нийт өр төлбөр 854.6 сая төгрөгөөр тайлагнагдсан ба үүний 97.2 хувь буюу 830.9 сая төгрөг нь нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой Тариат болон Өлзийт сумын төсөвт байгууллагуудад үүссэн халаалтын өр байна.	-	Зөвлөмж хүргүүлэх	Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ц.Мөнхнасан, Ж.Мөнхбат
Дүн		30.9			

6. Аймгийн ТЭЗ-аас ирүүлсэн асуудлын бүртгэлийн хариу



МОНГОЛ УЛС АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2 дугаар баг,
Утас/Факс: (976) 7033 3208,
И-мэйл: arkhangai.gov@gmail.com,
Вэбсайт: www.arkhangai.gov.mn

2021.04.23 № 01/508
танай 2021.04.22-ны № 206 -Т

Тайлбар санал хүргүүлэх тухай

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

а/мөнөмөр

Саналыг эртэй хэрх! /5,7-г/
- ортайлцуу ирсэн санал
болон хариуыг эрүүл!

Дүн - 14/12

Танай газрын 2021.04.22-ны өдрийн 206 тоот албан бичгээр ирүүлсэн аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын асуудлын бүртгэлтэй танилцлаа.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын асуудлын бүртгэлд тусгагдсан зөрчил дутагдал нь өмнөх аймгийн удирдлага, ажлын албатай холбоотой илэрсэн гэж ойлгож байна. Ийм учраас танилцаад танай байгууллагаас ирүүлэх зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авна гэсэн ойлголтоор гарын үсэг зурлаа.

Дараах зарим асуудлыг зөрчил дутагдлаас чөлөөлж өгөхийг хүсч санал, тайлбараа хүргүүлж байна. Үүнд:

Асуудлын бүртгэлийн 7 дахь асуудлыг төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй бүхэлд нь хамруулан ойлгож дүгнэлт хийж болохгүй юм. Энэ нь зөвхөн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, тоо чанарын үзүүлэлтийн тухайлсан асуудал.

Аймгийн төсвийн төслийг 11 сард, боловсруулж, 12-р сарын 05-ны дотор ИТХ-аар батлуулахад хөтөлбөр арга хэмжээний нэрээр төсвийн дүнг хуваарилж болдог, харин ямар ажил хийж, ямар тоо чанарын үзүүлэлт гаргах нь тодорхой болоогүй, салбарын сайд нартай гэрээ, аймаг, сум, байгууллагууд жилийн ажлын төлөвлөгөөгөө батлаагүй байдаг учраас хэрэгжүүлэхэд учир дутагдалтай, барагцаалсан тоо, чанарын үзүүлэлт батлуулахаар тайлагнахад учир дутагдал, бэрхшээлтэй болдог. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийг санхүүгийн нэгтгэсэн тайлан аудитаар баталжсаны дараа Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 5 дахь заалтын дагуу аймгийн ИТХ-д хэлэлцүүлж урьд оны үлдэгдлийг 2021 оны зарлагын эх үүсвэр болгож хуваарилахаар төлөвлөсөн юм. Энэ талаар Санхүү, төрийн сангийн хэлтсээс бичгээр тайлбар өгсөн болно.

Асуудлын бүртгэлийн 8 дахь дотоод хяналттай холбоотой асуудал нь аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст дотоод хяналт, төлбөр тооцооны ахлах мэргэжилтэн гэсэн нэг орон тооны ажилтан ажилладаг. Энэ ажилтан төрийн сангийн гүйлгээний өдөр тутмын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажлын чиг үүрэгтэй байдаг. Сангийн сайдын 2015 оны 65 дугаар тушаалаар батлагдсан дотоод хяналтын журмаар сумдын санхүүгийн албаны төрийн сангийн төлбөр тооцооны ажил жилд нэг удаа хяналт шалгалт хийж зөвлөн туслах ёстой байдаг. Гэтэл Санхүү төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт, төлбөр тооцооны ахлах мэргэжилтэн нь аймгийн төрийн сангийн өдөр тутмын гүйлгээ хянаж баталдаг

651230247

учраас цаг хугацаа, хүний нөөцийн хувьд сумдад тогтмол ажиллах хүрэлцээ боломжгүй байдгаас дотоод хяналт сулрах нөхцөл болдог.

Иймд Санхүү төрийн сангийн хэлтсийн дотоод хариуцсан ажилтны тоог нэмэгдүүлэх саналын дээд байгууллагад уламжилж өгөх. Нөгөө талаар Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 24 дүгээр тогтоол батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журмаар сумын Засаг дарга, Санхүү албаны дарга төрийн сангийн өдөр тутмын гүйлгээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй байдаг. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан аймгийн нэгтгэсэн тайлангийн зөрчлөөс чөлөөлж сумдад зөвлөмж хүргүүлж зөрчлийг арилгуулах саналыг хүргүүлж хүлээн авна уу.

Асуудлын бүртгэлийн 5 дахь асуудал: Тайлант онд 22 нэр төрлийн орлогоос 16 нэр төрлийн орлогыг 5581.2 сая төгрөгөөр давуулж, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийн орлого, газрын төлбөрийн орлого, хог хаягдлын хураамжийн орлого, ногдол ашиг, нэр заагдаагүй бусад орлогыг 109.3 сая төгрөгөөр тасалдуулж нийт дүнгээрээ 5471.9 сая төгрөгөөр орон нутгийн төсвийн орлогыг давуулан биелүүлсэн.

Үл хөдлөх эд хөрөнгийн татварын хувьд Төвшрүүлэх сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Бэрэнмайнинг", "Арган" компаниудын хөрөнгийн татварын 39.8 сая төгрөгийн өрийг барагдуулахаар арилжааны банкин дахь харилцах дансыг хааж, хөрөнгийг битүүмжилсэн, 2020 онд үйл ажиллагаа эрхлээгүйн улмаас ҮХЭХАТ төлөөгүй зэргээс шалтгаалсан байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн орлогын хувьд нь нотариатын үйлчилгээ багассан иргэний болон лавлагаа баримт цахимжсан, тамхи худалдаалах зөвшөөрөл шинээр нэмэгдэж олгогдоогүй, мөн ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А-272 тоот тушаалаар норматив тогтоосон тухай тул согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, суманд тогтоосон тул зөвшөөрлийн тоо багассан зэргээс шалтгаалан тасарсан болно.

Хог хаягдлын хураамжийн орлогын хувьд ковидтой холбоотой 2020 оны 12 сарын хогны төлбөрийг Засгийн газрын тогтоолоор чөлөөлсөн, Цэнхэр сумын Орхон багт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгжүүдээс хогны төлбөр авна гэж тооцоолсон боловч лиценц нь цуцлагдсан, Жаргалант сум утаагүй өрхийн тоонд төлбөр ногдуулсан, Ихтамир сумын хогны орлого он дамнаж төсөвт төвлөрүүлсэн зэргээс болж төлөвлөгөө 1,2 сая төгрөгөөр тасарсан байна.

Газрын төлбөрийн 34.6 сая төгрөгөөр тасарсан нь ашигт малтмал, газрын тосны газрын кадастрийн хэлтсийн даргын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн шийдвэрээр Цэнхэр сумын Орхон багт үйл ажиллагаа явуулж байсан 10 аж ахуйн нэгжийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалсантай холбоотойгоор уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч компаниуд нь 2020 онд үйл ажиллагаа явуулаагүй. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн газрын төлбөрийн нэхэмжлэхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар мэдээллийн санд үүсгээгүйтэй холбоотой.

Хувьцааны ногдол ашгийн хувьд Ар-Ус Ундарга ХХК нь 2019-2020 онуудад ашиггүй ажилласнаас шалтгаалсан зэргийг харгалзан үзэж зөрчлөөс чөлөөлж мөнгөн дүнгүйгээр зөвлөмж болгож өгнө үү.

Бусад асуудлуудаар илэрсэн зөрчил дутагдлыг шаардлага, зөвлөмжийн дагуу арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно.



Д.ЗОЛЖАРГАЛ

7. Адитын тайлан баталгаажуулсан тушаал



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/10

Цэцэрлэг

Тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 тушаалын 5 дугаар хавсралтын 2.4, 2020 оны а/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг тус тус баталгаажуулсугай.

2. Аудитаас өгөгдсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. “Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн аудитын тайлангуудыг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгөгдсөн зөвлөмж албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Н.Алтантуяад үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР

003010027

Дарга, тэргүүлэх аудиторын 2021 оны 04 дүгээр сарын

№...-ны өдрийн 4/10 тоот тушаалын хавсралт

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР ХҮРГҮҮЛСЭН АЛБАН
ШААРДЛАГА

№	Албан шаардлага хүргүүлсэн байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /сая төгрөг/	Хариуцсан аудитор
1	Аймгийн ТЕЗ	153/АО340209	115.1	Ж.Мөнгөншагай
2	Аймгийн ТЕЗ	154/АО340209	20.0	Н.Алтантуяа
3	Аймгийн ТЕЗ	155/АО340209	10.9	Н.Алтантуяа
4	Аймгийн ТЕЗ	156/АО340209	-	Н.Алтантуяа

8. Хүргүүлсэн албан шаардлага



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 154/АДЗ40209

Цэцэрлэг

АПА - 2021/01 - СТА - ТЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 20.0 сая төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2017 онд аймгийн засаг даргын хөтөлбөр арга хэмжээний зардлаас Хайрхан сумын малчин О.Доржтой шилмэл үүлдрийн хээлтүүлэгч бог малын үүлдэр угсааг сайжруулах төсөл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан 20.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон бөгөөд 2018 оны 10-р сард малчин О.Доржийн хүсэлтийн дагуу 2018, 2019, 2020 онуудад шилмэл омгийн хуц нийлүүлэн зээлийг төлж барагдуулах өөрчлөлтийг оруулсан боловч гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, авлага барагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтууд, 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн "Шилмэл омгийн хээлтүүлэгч мал нийлүүлэх гэрээний хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны а/95 дугаар тушаалаар баталсан төлбөрийн акт, албан шаардлага өгөх журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-ыг албан шаардлага өгөхөд харгалзана гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, тайланд тусгагдсан авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажиллах
2. Цаашид төсөв санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийг мөрдөж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах

Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Д.Золжаргал, СТСХ-ийн дарга Ж.Мөнхбат, ХОХБТХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Билэг-Өрнөх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Тэргүүлэх аудитор

Д.Уламбаяр

6517143880
440A0032 9001034

000040013



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 155/А0340209

Цэцэрлэг

APA - 2021/01 - CTA - TE3

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 10.9 сая төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн мал хамгаалах сангийн тайланд тусгагдсан 10.9 сая төгрөгийн авлагын 3.9 сая төгрөг нь 2013-2016 онуудад, 7.1 сая төгрөг нь 2018 онд үүссэн хувь хүнээс авах өвс тэжээлийн 2-7 жилийн насжилттай авлагын тооцоо байгаа бөгөөд хоорондын тооцоо нийлсэн актгүй, 2020 онд эдгээр авлагуудыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны а/95 дугаар тушаалаар баталсан төлбөрийн акт, албан шаардлага өгөх журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-ыг албан шаардлага өгөхөд харгалзана гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Авлагыг тооцоо нийлж баталгаажуулан барагдуулах арга хэмжээг авч, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах
2. Мал хамгаалах сангийн бүртгэл тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу хөтөлж хэвших.

Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Д.Золжаргал, нягтлан бодогч Ц.Батцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Тэргүүлэх аудитор

Д.Уламбаяр


6512143980
70A0052 9001034

000010003



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар

156/А0340209

Цэцэрлэг

АРА - 2021/01 - СТА - ТЭС

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 140 мэдээллээс 61 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.10 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын ерөнхий аудиторовн 2020 оны а/95 дугаар тушаалаар баталсан төлбөрийн акт, албан шаардлага өгөх журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-ыг албан шаардлага өгөхөд харгалзана гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд байршуулж хэвших
2. Шилэн дансны мэдээлэл оруулах холбогдох ажилтны ажлын хариуцлагыг өндөржүүлэх

Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Д.Золжаргал, СТСХ-ийн дарга Ж.Мөнхбат, ХОХБТХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Билэг-Өрнөх, ОНӨГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Оюун-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Тэргүүлэх аудитор

Д.Уламбаяр

003040310